



ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИ

2019 ОНЫ ТАЙЛАН



3-30-2020

НЭГ. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Ган хийц ХК нь 1985 онд жилдээ 6000 тонн төмөр хийц үйлдвэрлэх хүчин чадалтайгаар анх ашиглалтад орж байсан бөгөөд Үйлдвэрийн ба иргэний барилгын бүх төрлийн төмөр хийц үйлдвэрлэх, угсрах, зураг төсөл боловсруулах, даацын болон даацын бус төмөр хийц эдлэл, даралтат сав хоолой, уурын зуухны бүх төрлийн тогоо, эд анги зэрэг олон төрлийн төмөр хийцийг үйлдвэрлэн ажилладаг. 1992 оны 12 дугаар сарын 14-ны өдөр Ган хийц Хувьцаат компани болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

Манай компани нь үүсгэн байгуулагдсанаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж, компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр тогтоосон хугацаанд зарлан хуралдуулж, хурал хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зар мэдээг хүргэх ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нөхцөл, журам, шаардлагын дагуу хэрэгжүүлж хэвшүүлж ирсэн ба хувьцаа эзэмшигчдэд 1993-2018 онуудад тодорхой хэмжээний ногдол ашиг хуваарилсаар ирсэн.

2019 онд Ган хийц ХК-ийн үндсэн үйлдвэрлэл дараах чиглэлүүдээр явагдсан. Үүнд:

1. Төмөр хийц эдлэл үйлдвэрлэл
2. Барилга угсралт

Ган хийц ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг 121977600 төгрөг, ЗАА зардлын төсвийг 647118700 төгрөгөөр, борлуулалтын хэмжээг 2.6 тэрбум төгрөгөөр баталж өгсөн ба гүйцэтгэлээр дараах байдалтай байна.

№	Нэр	Төсвийн гүйцэтгэл
1	ГУЗ-ийн зардал	92 298 964.31
2	ЗАА зардал	537 322 819.7
3	Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралт	1 151 067 496.15

2019 онд төсөвт төлсөн татвар

Д/д	Үзүүлэлт	2019 онд төлсөн татвар
1	Нийгмийн даатгалд	101 500 000.00
2	ААНОАТ	5 985 654.74
3	Үл хөдлөхийн татвар	5 792 980.00
4	ХАОАТ-ын татварт	25 501 273.26
5	Тээврийн хэрэгслийн татварт	658 700.00
6	НӨАТ-ийн татварт	137 559 745.91
7	Газрын татварт	4 000 000.00
8	ХША-ны төлбөрт /2013-2017 он/	7 756 809.00
	Нийт дүн	288 755 162.91
Ган хийц ХК оны 2019 онд хийгдсэн ажил		
Д/д	Материалын марк	
1	Мак цемент	
2	Фүжи девелопмент	
3	Цэцэн урчууд	
4	Агайын	
5	Хан богд	
6	Хос санаа	
7	БМСМ	
8	Акми холдинг	
9	ЗХ-ний 17-р анги	
10	Айсмарк ХХК	
11	Жи си ар ХХК	
12	Ар эс ти тур ХХК	
13	Ган эрдэнэ констракшин	
14	Мобиком корпораци /цах/	
15	Мэйжор дриллинг ХХК	
16	Шилдээд ХХК	
	<i>Дун</i>	1,151,067,496.15

ХОЁР. УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ын хурлаар баталсан ЗАА-н орон тооны бүтцийн дагуу зохих хүмүүсийг авч ажиллуулсан ба зарим нэг орон тоон дээр хавсран ажиллаж байлаа.

Ган хийц ХК нь Захиргаа аж ахуй, Инженер техникийн алба, Засвар үйлчилгээний хэсэг, үйлдвэрлэх цех гэсэн 4 хэсгээс бүрддэг.

- 2019 онд 36 орон тоо дээр 56 хүн ажиллаж байна.
- 2019 оны 10 дугаар сараас Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Д.Оюунзулыг томилон ажиллуулсан бөгөөд 2020 оны 02-р сарын 14-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилсон.

2019 оны ТУЗ болон Захиргаа , үйлчилгээний хэсгийн орон тоо цалингийн санг төсвийн гүйцэтгэл

№		Төсөв	Гүйцэтгэл
1	Зархиггаа, үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан	358 620 000	234 511 946.3
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардал	53 760 000	54 290 160

ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл


Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

2019 оны 04 дүгээр сарын 26 -ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонгон баталсан. Ган хийц ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат гишүүнээр М.Даваасүрэн, Б. Эрдэнэбаяр, Ц.Пүрэвжаргал, Б.Ганбат, Э.Долгорсүрэн, Ц.Хангай нарыг, Хараат бус гишүүнээр Д.Сайнбаяр, Д.Энхбаатар, Ц.Жанлав нарыг сонгож баталсан.

2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар М.Даваасүрэн, нарийн бичгээр О.Ууганцэцэг,

Аудитын хорооны даргаар Ц.Жанлав, Гишүүдээр Э.Долгорсүрэн, Д.Сайнбаяр нарыг, Цалин урамшууллын хорооны даргаар Д.Сайнбаяр, гишүүд Ц.Хангай, Д.Энхбаатар нарыг, Нэр дэвшүүлэх хорооны даргаар Д.Энхбаатар, Б.Эрдэнэбаяр, Ц.Жанлав нарыг сонгон томилсон.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2019-2021 ОНЫ БҮРЭЛДЭХҮҮН



ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны тайлан

Тус хороо 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланд туссан хэдэн хэдэн асуудлыг танилцуулья.

1. Компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг их хуучирсан шаардлага хангахгүй болсон байна. 1998 оноос хойш хууль, дүрэм, журам өөрчлөгдсөн.

2020 оны 1 дүгээр сараас Татварын багц хууль өөрчлөгдсөн. НББ-ийн стандартын дагуу 2020 оны нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу боловсруулах ажлыг 2020 оны төлөвлөгөөнд оруулж, хамтран ажиллаж шинэчлэн өөрчлөнө.

2. Компанийн НББ-ийн анхан шатны баримтыг шалгаж заавар зөвлөгөө өгч ажилласан. 2019 онд 4 удаа ирж Нягтлан бодох бүртгэлийг шалгасан.
3. Гүйлгээ балансыг шалгаж, заавар зөвлөгөө өгч ажилласан.
4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой элэгдэл хорогдлыг тооцож, зөвлөгөө заавар өгсөн гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Ган хийц ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд “Ай жэй эй эйч аудит ”ХХК Аудитын үйлчилгээний компани ажиллаж байна.

ГУРАВ. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2019 оны Орлогын дэлгэрэнгүй тайлан

Д/д	Үзүүлэлт	2019 оны 12 сарын байдлаар
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1 151 067 496.15
2	Борлуулалтын өртөг	855 035 573.35
3	Нийт ашиг (алдагдал)	296 031 922.80
4	Хүүний орлого	49 659.29
5	Бусад орлого	
6	Ерөнхий ба удирдлагын зардал	527 435 033.89
7	Бусад зардал	9 620 814.00
8	Гадаад вальтын ханшийн зөрүүний олз (гарз)	177 454.79
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-240 796 811.01
10	Орлогын албан татвар	4 965.92
11	Нийт дүн	-240 801 776.93

2019 оны Санхүү байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 1-р сарын 1	2019 оны 12-р сарын 31
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	47 210 818.48	25 308 571.64
2	Дансны авлага	1 371 662 948.64	1 382 920 212.40
3	Бараа материал	296 529 151.29	450 394 684.13
4	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1 510 939 326.08	1 889 780 410.46

5	Эргэлтийн хөрөнгийн дүн	3 226 342 244.5	3 748 403 878.64
6	Үндсэн хөрөнгө	1 399 120 585.77	1 325 495 874.08
7	Урт хугацаат хөрөнгө оруулалт	323 132 612.61	323 132 612.61
8	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1 722 253 198.39	1 648 628 486.70
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4 948 595 442.89	5 397 032 265.34
10	Дансны өглөг	350 016 090.81	1 365 882 353.88
11	Цалингийн өглөг	27 478 104.70	5 469 412.10
12	Татварын өр	234 507 848.49	220 680 013.90
13	НДШ - ийн өглөг	47 604 380.94	40 116 540.19
14	Богино хугацаат зээл	1 295 410 421.14	549 481 421.14
15	Урьдчилж орсон орлого	2 191 265 354.21	2 664 177 438.46
16	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4 146 282 200.30	4 845 807 179.68
17	Эздийн өмч	24 246 400.00	24 246 400.00
18	Эздийн өмчийн бусад хэсэг	798 700 593.97	798 700 593.97
19	Хуримтлагдсан ашиг	-20 633 751.37	-271 721 808.30
20	Эздийн өмчийн дүн	802 313 242.60	551 225 185.67
21	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4 948 595 442.90	5 397 032 365.35

Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа гаргасан тухай мэдээлэл

- Хас банкны үндсэн зээлийн төлбөрт 2019 онд 745 929 000 төгрөг төлсөн.
- Хас банкны үндсэн зээлийн үлдэгдэл 549 481 000 төгрөгийг 2020 оны 1 сард төлж дууссан.

ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тав болон түүнээс дээш хувийг эзэмшигчийн мэдээлэл

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Эзлэх хувь
М.Даваасүрэн	173580	71,59
Хасвуу ХХК	44263	18,25

ТАВ. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2018 онд цэвэр ашгаас нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн хэмжээг 50 төгрөгөөр тогтоож, 242464 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 122 хувьцаа эзэмшигчдэд 12123200 төгрөгийн ногдол ашиг хуваарилхаар баталсан бөгөөд 2019 оны 10 дугаар сард Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ байгуулан 99 хувьцаа эзэмшигчийн 13880 ширхэг хувьцаанд ногдох 624600 төгрөгийг шилжүүлэн, дансанд нь байршуулсан бөгөөд 22 хувьцаа эзэмшигчийн 228782 ширхэг хувьцаанд ногдох ногдол ашгийг компани дээрээс тараасан.

Компанийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 48.3, 48.4 заалтуудыг үндэслэн тооцож, 2019 оны Санхүүгийн тайланг хархад Ган хийц ХК нь -240 801 776,93 төгрөгийн алдагдалтай гарсан тул энэ жил ногдол ашиг тараахгүй гэсэн ТУЗ-ийн шийдвэр гарч, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар болсон.